



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/346

Булган сум

“Булган хангай” ардын өв соёлын
наадам зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV Хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” XIV/01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын Ард түмний дахин давтагдашгүй соёлын үнэт зүйл, соёлын биет бус өв, ардын урлагийн төрөл зүйлүүдийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Булган хангай” ардын өв соёлын наадмыг зохион байгуулсугай.

2. Наадмыг зохион байгуулахад шаардагдах 9,577,000 (есөн сая таван зуун далан долоон мянга) төгрөгийг Бүх нийтийн соёлын боловсрол олгох төлөвлөгөө хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

